

ҮНДЭСНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ХЯНАЛТЫН

ХОРООНЫ ХУРЛЫН ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ

2019 оны 06 сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

Хурал ҮЗЗ-ийн Ажлын Албаны байранд 2019 оны 06 дугаар сарын 14-ний өдөр 12:30 цагт эхлэв.

Хуралд оролцогчид:

1. Ц.Даваасүрэн, Монголын Сүрьеэтэй Тэмцэх Нэгдсэн Холбоо
2. Г.Нямпүрэв, Залуус Эрүүл Мэнд ТББ
3. С.Энхжин, ЭМЯ-ны ХШҮДАГ-ын мэргэжилтэн
4. Др.Индермохан Нарула, СОНА
5. М.Сэргэлэн, ХЗН-ийн ХШҮ-ний мэргэжилтэн

Гишүүдийн ирцийн бүртгэлийг хавсралтаар оруулав. /Хавсралт 1/

Хөтөлбөр 1. Гишүүд Хяналтын Хорооны Хурлын хөтөлбөрийг батлан, ҮЗЗ-ийн зохицуулагч Б.Оюундарь өмнөх хурлын шийдвэрийн биелэлтийг танилцууллаа. Үүнд:

Хөтөлбөр 3. Гишүүдийн саналаар ХЗН-д дараах үүргийг өглөө. Үүнд:

1. ҮЗЗ-ийн Хяналтын хорооны гишүүдэд аливаа мэдээллийг нарийвчилсан байдлаар дэлгэрэнгүй хүргэж байх ба яг шийдвэрлэж чадахгүй байгаа асуудлаа бидэнд ирүүлж байна уу.
2. ҮХА-тай уулзалт зохион байгуулж Шилжилтийн үеийн төлөвлөгөөний талаар хэлэлцэх. ЭМЯ-ХЗН-ээс ҮЗЗ-ийн ажлын албаны хүсэлтээр мэдээллийг цаг тухайд нь ирүүлдэг.

Хөтөлбөр 4. Хяналтын төлөвлөгөөний дагуу УБ хот болон хөдөө орон нутгуудад хийгдэх хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах ажлын газар болон товгыг хэлэлцэн батласны дагуу

- ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн ТСА, ХӨСҮТ-ийн БЗДХ-ын ТСА, Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбоо (МСЭМХ), Монголын Өрхийн Анагаах Ухааны Мэргэжилтнүүдийн Холбоо (МӨАУМХ), Хүүхэд өсвөр үеийг ивээх төв зэрэг байгууллагуудаар 2018 оны 11 дүгээр сарын 20-нд
- Увс, Завхан аймгуудаар танилцах айлчлалыг 2019 оны 01 сарын 22-26-нд,
- Налайх дүүргийн ЭМТ, “Төгс Бүсгүйчүүд” ТББ, “Шинэ Өөдрөг Амьдрал” ТББ зэрэг байгууллагуудад 2019 оны 03 сарын 21-нд,
- Төв, Дундговь, Өмнөговь аймгуудаар 2019 оны 04 сарын 08-11-нд,
- Баянхонгор, Өвөрхангай аймгуудад 2019 оны 04 сарын 22-26-нд тус тус танилцах айлчлалуудыг хийж тайланг нийт гишүүдэд хүргүүлсэн. ҮЗЗ-ийн

танилцах айлчлалтай холбоотой асуумж, зөвлөмж, ерөнхий удирдамжийг Ажлын Алба бэлтгэн ҮЗЗ-ийн гишүүдэд хүргэх үүргийг өгсөнийг биелүүлсэн.

Эдгээр шийдвэрүүдийн дагуу өмнөх хурлын шийдвэрийн биелэлт хэрэгжээд явж байна.

Хөтөлбөр 2. 2018 онд хэрэгжүүлсэн төслүүдийн үйл ажиллагааны биелэлтийг хянах самбараас танилцуулах /Хавсралт 2/

ДОХ-ын төслийн хянах самбарын мэдээлэл

Энэхүү хянах самбар дээр Биеэ үнэлэгчдийн хөтөлбөр, ЭБЭ-ийн хөтөлбөр, ГС-аас шилжүүлсэн санхүүжилтын мэдээлэл, хугацаат болон болзолт ажлыг хийж гүйцэтгэсэн байдал, ХШҮ-ний төлөвлөгөө болон Болзолт ажлын гүйцэтгэл тусгагдсан байна. Хүний нөөцийн мэдээлэл дээр ХЗН-д 16 ажилтан ажиллахаас одоогоор 15 ажилтан ажиллаж байгааг оруулсан байна.

Одоогоор ДОХ-ын төслийн хүрээнд 6 СХА-тай гэрээ байгуулан ажиллаж, тайлангуудаа цаг тухайд нь хүлээн авч байна. Мөн өмнө бид ДОХ-ын эмийг хүлээн авдаг байхад бүртгэдэг байсан боловч одоо эмийг хүлээн авахаа больсон тул хянах самбарын энэ талын мэдээлэл хоосон байдаг болсон.

Хөтөлбөрийн хүрээнд ЭБЭ-86%, ЭБҮ-102%-ийн биелэлттэй явж байгааг хүснэгтээс харж болох бөгөөд шинжилгээнд хамрагдалт 91% байна. Түүнчлэн Ретровирусын эмчилгээ 81% байгаа ба эмчилгээг 3 үзүүлэлтээр ангилдаг болсон. ХДХВ, сүрьеэгийн хавсарсан халдвартай хүмүүсийн эмчилгээ 100% явагдсан байна. Цаашид хяналтын хорооны үйл ажиллагааны хүрээнд үзүүлэлтэд хүрээгүй үйл ажиллагааг сайжруулах боломжтой. Улмаар шалгуур үзүүлэлтүүддээ хүрэхгүй байгаа шалтгаан, үйл ажиллагааг шахаад яваад буйгаас үүдэн үзүүлэлтүүдэд хүрэхгүй байгаа талаар хэлэлцэх хэрэгтэй. Эдгээр мэдээлэл бол ГС-д ХЗН-ээс хүргүүлсэн тайланг нэгтгэсэн байдлаар ҮЗЗ-ийн гишүүдэд ойлгомжтой товч байдлаар хүргэх зорилгоор боловсруулсан мэдээлэл болно. 2018 онд ГС-аас ДОХ-ын төсөл дээр А2, Сүрьеэгийн төсөл дээр В1 гэсэн үнэлгээг авсан.

Г.Нямпүрэв: Бид СХА-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон санхүүжилт орж ирсэн байгаа байдлыг уялдуулан шийдвэрлэх хэрэгтэй. Чухам яг ямар шалтгааны улмаас зарим үйл ажиллагаа цагтаа хэрэгжээгүй гэдэг мэдээллийг тусад нь тайлбар багана гарган тайлбарлах хэрэгтэй санагдаж байна. Энд тухайн байгууллагаас гадна өөр бусад хүчин зүйлсийн нөлөө ч ихээхэн тусдаг гэдгийг харгалзан үзэх хэрэгтэй.

Ц.Даваасүрэн: Бид шалгуур үзүүлэлтүүддээ яагаад хүрээгүй шалтгаан, санхүүжилтээс болоод үйл ажиллагаанд хүрч ажиллахгүй байгаа эсэх мэдээллийг тухайн СХА-аас авч тайлбарласнаар зөвлөмж өгөх боломжтой болно.

Г.Нямпүрэв: Аливаа шалтгааны улмаас биелээгүй бол шалтгааныг маш сайн тусгаж байх хэрэгтэй. Хагас жил тутамд тайланг хүлээн авч хэрэгжүүлэх талаар ажиллах хэрэгтэй. Тиймээс ХЗН-ээс тайлбарыг илүү тодорхой оруулуулж байх саналтай байна.ш.

С.Энхжин: Хийгээгүй ажилдаа хэрхэн хүрэх вэ? Оношлуур тасарснаас шинжилгээ хийгдээгүй тохиолдолд юу хийж байгаа вэ?

М.Сэргэлэн: ЭБҮ-ийн сургалтанд очоод зорилтот үзүүлэлтийг нь танилцуулан ажлаа эрчимжүүлэх хэрэгтэй талаар сануулсан. Хугацаа хоцорсон үйл ажиллагааны санхүүжилтын үлдэгдэл хадгалагдан үлддэг. Ихэнх тохиолдолд ханган нийлүүлэлттэй холбоотойгоор дээрх асуудал үүсээд байна. Оношлуурын хувьд одоогоор ЗЭМ, Төгс бүсгүйчүүд ТББууд Нийслэлээс эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх эрх хүсэхэд нэг нь дэмжигдээгүй байдалтай байна.

Сүрьеэгийн төслийн хянах самбарын мэдээлэл

Санхүүжилтын хувьд ГС-аас 3 сая 339 мянган ам.доллар ирүүлсэнээс СХА чид-1 сая 900 мянган ам.долларыг зарцуулсан байна. Үүнтэй холбоотой зөрүүгийн тайлбарыг ХЗН-ээс өгч болно.

Сүрьеэгийн тусламж үйлчилгээний хувьд:

Хугацаат ажил: 1 ажил хийгдээгүй 2 ажил хүлээгдэж байна

Болзолт: 3 ажил хийгдсэн.

Хийгдээгүй ажлын хувьд ЭМЯ-наас тусдаа өвчин бүрт хүний нөөцийн төлөвлөгөө гаргахгүй гэсэн тайлбарыг ирүүлсэн. Тиймээс би мастер төлөвлөгөө гарахад энэ талаар тусгана гэсэн тайлбар өгч байна.

- ХШҮ-ний төлөвлөгөө
- Шилжилтийн үеийн төлөвлөгөө
- Женекспэртийг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан хүргүүлэх шаардлагатай байна.

Сүрьеэг үнэхээр хангалтгүй илрүүлж байна. 2018 онд 5000 хүн илрүүлэх зорилттой байснаас 3800 хүнийг илрүүлсэн. Энэ талаар бид 2019 онд X-ray орж ирвэл илрүүлэлтийг сайжруулна гэсэн тайлбар өгөөд явж байна.

Ретромицин эмийн хэрэглээний хэсэгт тайлбар өгөхөд нийт сүрьеэ бага байгаа болохоор ОЭДС улам бага болж байна. Тиймээс 2018 онд 240 хүн эмчлэх байснаас 194 хүн эмчлүүлсэн байгаа тул энэ эмийн зарцуулалт хүрээгүй байдалтай харагдаж байна.

С.Энхжин: ЭМЯ-ны 2021 он хүртэлх Хүний нөөцийн төлөвлөгөөг би танайхруу хүргүүлбэ. Түүн дээрээс хэрэгтэй мэдээллээ шалгаарай.

Ц.Даваасүрэн: Өвчлөлийн талаарх өмнөх оны мөн үетэй харьцуулан судалж, бүх аймаг, дүүргүүдэд 2019 оны хувьд илрүүлгийг нэмэгдүүлэхийн тулд ханган нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг бүрэн дүүрэн ашиглах шаардлагатай гэсэн зөвлөмж хүргүүлье.

С.Энхжин: ХЗН-ийн зүгээс ХШҮ-ний тайланг манайд ирүүлнэ үү. Бид төслийн тоног төхөөрөмж, төслүүдийн биелэлтийн талаар мэдээлэл авах хүсэлтэй байна. Улмаар бид үйл ажиллагааны хяналтаар явахдаа уялдуулан давхар хяналт тавих бололцоо бүрдэх болно.

М.Сэргэлэн: Энэ хянах самбар дээр тайлбарын багана нэмэх хэрэгтэй санагдаж байна. Тэрхүү баганадаа үйл ажиллагааны аливаа саад бэрхшээл болон хоцорсон үйл ажиллагааны шалтгааныг оруулж өгье.

Хяналтын хорооны хурлын шийдвэр: Хянах самбарыг хагас жил тутамд ҮЗЗ-ийн Ажлын Албанд ирүүлэн Хяналтын хорооны гишүүдээс зөвлөмжийг авч байх хэрэгтэй. Тиймээс 2019 оны эхний хагас жилийн мэдээллийг дараагийн удаагийн Хяналтын хорооны хурлаар оруулж хэлэлцүүлье. Зөвлөмж хэсэгт нь гишүүдийн саналыг тусгаад гишүүдэд ирэх Даваа гарагт хүргүүлье. Түүнчлэн хянах самбарт тайлбар хэсгийг нэмж тусгахаар гишүүд санал нэгтгэйгээр шийдвэрийг баталлаа.

Хөтөлбөр 3. 2017 онд хэрэгжээд дууссан төслүүдэд аудитийн үнэлгээ хийсэн тайланг танилцуулах

Хяналтын хорооны хурлын шийдвэр: ХЗН-ийн зүгээс ирэх долоо хоногт багтаан ирүүлэх хэрэгтэй гэж гишүүд хэлэлцэн тогтов.

Хөтөлбөр 4. 2018-2019 оны хяналтын төлөвлөгөөний биелэлтийг танилцуулах

2018-2019 оны хяналтын төлөвлөгөөний биелэлт

	Үйл ажиллагаа	Биелэлт (хувь)	Тайлбар
	Жилийн ажлын төлөвлөгөөний дагуу гол хяналт тавих үйл ажиллагаанууд		
	ҮЗЗ-ийн хурал дээр тайлагнах: хяналтын үйл ажиллагаа болон Хянах самбар бүрийн талаарх мэдээлэл өгөх, зөвлөмжүүдийг бэлтгэн танилцуулах	100%	ҮЗЗ-ийн 80 дахь удаагийн хурлаар хэлэлцсэн
	Хяналтын Хорооны хурлыг улирал тутам зохион байгуулах	25%	Хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах ажлыг түлхүү зохион байгуулсан, хорооны дарга томилогдоогүй
	Ерөнхий хяналтыг газар дээр нь очиж хийх ажлыг зохион байгуулах	83%	УБ: 11-р сард ХӨСҮТ, МСЭМХ, МӨАУМХ 1-р сард Увс, Завхан 3-р сард Налайх дүүрэг, ТББ Хөдөө орон нутагт: 1-р сард Увс, Завхан

			4-р сард Төв, Дундговь, Өмнөговь 4-р сард Баянхонгор, Өвөрхангай
	Хяналтын хорооны өөрийгөө үнэлэх үнэлгээг хийх	-	
	Улирал бүр хамтрагч талууд болон Глобаль санд хяналтын тайланг мэдээллэх	100%	
Хяналт тавих чиг үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, хяналт тавих чадавхийг бий болгох			
	Жилийн Хяналтын төлөвлөгөөг боловсруулах	100%	
	Жилийн хяналтын төсөв боловсруулах	100%	
	Хяналтын хороонд туслалцаа үзүүлэх техникийн шинжээчдийг тодорхойлох (шаардлагатай үед)	-	шаардлага гараагүй
	Хяналтын хорооны гишүүдэд чадавхижуулах, чиг баримжаа олгох сургалт зохион байгуулах	-	шаардлага гараагүй
Глобаль сангийн төслүүдийн тухай тайлан эсвэл байгаа мэдээллийг ашиглах замаар мэдээлэл цуглуулах			
	Хяналтын хороонд төсөл бүрийн санхүү, удирдлага, хөтөлбөрийн гүйцэтгэлийн явцыг ҮХА-аар (ХЗН) танилцуулах ажлыг зохион байгуулах, ҮХА болон СХА-ийн төлөөллийг өөрт тулгамдаад байгаа аливаа асуудал, саад бэрхшээлийн талаар танилцуулга тайлбар хийлгэх	-	
	Туслах материалуудын хуулбарыг хүлээн авч нягтлах.	-	
	Глобаль сангийн менежментийн захидал & Төслийн үзүүлэлтүүд болон бусад мэдээллийг дүгнэх, Ерөнхий хяналтыг газар дээр нь очиж хийх ажлын үр дүнг хэлэлцэх, зөвлөмж өгөх чиглэлээр ҮХА-тай уулзалт зохион байгуулах.	100%	ҮЗЗ-ийн хурлуудаар хэлэлцсэн
Ерөнхий хяналтыг газар дээр нь очиж хийх ажил болон ҮХА-СХА-ийн гүйцэтгэлийн тайлан дээр үндэслэн Глобаль сангийн төслүүдийн тухай мэдээлэл цуглуулах			
	Зорилтуудыг боловсруулах; санал асуулга / Ерөнхий хяналтыг газар	100%	сайжруулсан

	дээр нь очиж хийх ажлын тайлангийн маягтыг шинэчлэн сайжруулах		
	Танилцах айлчлалын хуанли боловсруулах	100%	
	Шаардлагатай үед асуудлыг шийдвэрлэх айлчлалыг шуурхай зохион байгуулах	-	шаардлага гараагүй
Хянах самбар болон бусад хяналтын үйл явцад тулгуурлан мэдээллийн дүн шинжилгээг хийх			
	Төсөл бүрийн хянах самбарын мэдээлэл дээр хорооны бүрэлдэхүүнээрээ дүн шинжилгээ хийж техникийн зөвлөмж гаргах	-	Хянах самбар жил тутамд гардаг тул 2018 оны хянах самбарыг 2019 оны 6-р сард хэлэлцэх
	Асуудал, саад бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар ҮЗЗ-ийн зөвлөмж боловсруулах	100%	ҮЗЗ-ийн хурлаар ҮХА-д зөвлөмж өгсөн
ҮЗЗ-ийн анхаарах шаардлагатай асуудал, саад, бэрхшээлийг шийдвэрлэх арга хэмжээ авах, үр дүнг эргэн хянах			
	Тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд ҮЗЗ-ийн шуурхай хурал зарлан хуралдуулах	-	шаардлага гараагүй
	Дараагийн ҮЗЗ-ийн хурал дээр асуудлыг шийдвэрлэсэн байдлын явцийг тайлагнах	-	хүлээгдэж байгаа
Хяналтын үйл ажиллагааг баримтжуулан, ҮХА-д тайлан болон шийдвэрийн гүйцэтгэлийг тайлагнах			
	Тайлангийн маягтуудыг ашиглан бүх үр дүнг баримтжуулах	100%	ТОГТМОЛ
	Бүх баримт бичгийг архивт хадгалах	100%	

С.Энхжин: Миний харж байгаар энэ үйл ажиллагааны хэрэгжилтийн тайлан шаардлага хангахгүй байна. Нэмж сайжруулаад надад ирүүлбэл би засаад та бүхэнд буцаагаад хүргэе.

Г.Нямпүрэв: Хяналтын хорооны хурлын ажиллагаа болон хяналтын үйл ажиллагааны төлөвлөгөөг боломжит байдлаар нэгтгэн ажлын төлөвлөгөөнд оруулах хэрэгтэй.

Ц.Даваасүрэн: Цаашид үйл ажиллагааны төлөвлөгөөг батлахдаа нэгтгэн оруулах нь зүйтэй санагдаж байна.

Б.Оюундарь: Та бүхний саналыг хүлээн авлаа. ҮЗЗ-ийн хурлаар Хяналтын хорооны биелэлтийн талаар товчхон танилцуулах гишүүнийг сонгоно уу.

С.Энхжин: Миний ажил ойрын өдрүүдэд давхцаж байгаа боловч та бүхэн нэгтгээд ирүүлбэл би өөрийн хэмжээнд нэмж сайжруулан ҮЗЗ-ийн хурлаар гишүүдэд танилцуулах боломжтой.

Хяналтын хорооны хурлын шийдвэр: ҮЗЗ-ийн 81 дэхь хурлаар Хяналтын үйл ажиллагаа болон Хянах самбарын талаарх мэдээлэл өгч, зөвлөмжүүдийг бэлтгэн танилцуулах болон 2019-2020 оны ҮЗЗ-ийн хяналтын төлөвлөгөөг танилцуулахаар Хяналтын хорооны гишүүн С.Энхжинг гишүүд санал нэгтгэйгээр сонголоо.

Хөтөлбөр 5. 2019-2020 оны Хяналтын төлөвлөгөөг хэлэлцэн батлах (Хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах ажлын тов болон газруудыг хэлэлцэн шийдвэрлэх)

Б.Оюундарь: ДОХ, сүрьеэгийн төсөл хөтөлбөрүүдэд өнгөрсөн жилүүдэд Газар дээр нь очиж танилцсан орон нутгуудын талаар мэдээлэл өглөө. Түүнчлэн

2018-2020 онуудад хэрэгжих ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн шинэ төслийг хэрэгжүүлэх
Салбар хүлээн авагч байгууллагууд

ХДХВ/ДОХ:

1. ХӨСҮТ
2. Залуус эрүүл мэнд ТББ (Эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд /ЭБЭ/ олон нийтэд чиглэсэн);
3. Төгс бүсгүйчүүд ТББ (Эмэгтэй биеэ үнэлэгчидэд чиглэсэн);
4. Гал голомт үндэсний хөдөлгөөн ТББ (ХДХВ, ДОХ ба хүний эрхийг хамгаалах асуудлаар бодлого, эрхзүйн орчныг боловсронгуй болгох; ХДХВ, ДОХ-ын хариу арга хэмжээний олон салбарын оролцоог хангах таатай орчинг бүрдүүлэх);
5. Шинэ өөдрөг амьдрал ТББ (Халдвартай олон нийтэд чиглэсэн);
6. Хүүхэд өсвөр үеийг ивээх төв (Хүүхэд залуучуудруу чиглэсэн).

Сүрьеэ:

1. ХӨСҮТ
2. Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг (Хоолтой эмчилгээ, гэрээр эм хүргэх үйлчилгээ);
3. Монголын сумын эмч мэргэжилтний холбоо (Сорьц тээвэрлэх тогтолцоог бэхжүүлэх);
4. Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтэнүүдийн холбоо;
5. Монголын улаан загалмайн нийгэмлэг (Орон гэргүйчүүдэд чиглэсэн);
6. ШШГ Хорих 429-р анги.

Хяналтын хорооны хурлын шийдвэр: Гишүүд ярилцсаны эцэст 2019-2020 оны Газар дээр нь очиж ажиллах байгууллагуудын хугацааг дараах байдлаар баталлаа. Эдгээр

танилцах айлчлалд оролцохоор явахдаа холбогдох байгууллагуудаас мэдээллийг өмнө нь авч оролцох гишүүдэд хүргэх үүргийг ҮЗЗ-ийн Ажлын Албанд өглөө.

Ерөнхий хяналтыг газар дээр нь очиж хийх ажлыг зохион байгуулах

		Ерөнхий хяналт хийх газар	<u>Хугацаа</u>	Үндэслэл
1	<u>Улаанбаатар хот</u>	<ul style="list-style-type: none"> • ШШГ Хорих 429-р анги. 	08-р сарын 4 дахь долоо хоногт	<ul style="list-style-type: none"> • Хоригдлуудад сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг
2		<ul style="list-style-type: none"> • Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг • Монголын улаан загалмайн нийгэмлэг 	09-р сарын 1-2 дахь долоо хоногт	<ul style="list-style-type: none"> • ТББ нь сүрьеэгийн тусламж үйлчилгээг УБ хот болон хөдөө орон нутагт үзүүлдэг; • ТББ орон гэргүйчүүдэд сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг.
3		<ul style="list-style-type: none"> • Гал голомт үндэсний хөдөлгөөн ТББ • Залуус эрүүл мэнд ТББ (ЗЭМ ТББ) 	01-р сарын 2 дахь долоо хоногт	<ul style="list-style-type: none"> • шийдвэр гагагч нарт нөлөөлж эрх зүйн таатай орчинг сайжруулах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг • ХДХВ/ДОХ-ын чиглэлээр Эрсдэлт бүлгийн хүн ам болон ЭБЭ олон нийтэд хүрч ажилладаг
4		<ul style="list-style-type: none"> • Чингэлтэй дүүргийн нэгдсэн эмнэлэг • Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг 	2-р сарын эхний долоо хоногт	<ul style="list-style-type: none"> • Сүрьеэгийн шинэ төслийн хүрээнд тавигдах агааржуулалтын систем байршуулах 2 дүүргийн нэг. • Эмнэлгийн шинэ байранд орно.
1	<u>Хөдөө орон нутаг</u>	Булган, Хөвсгөл	9-р сарын 3 дахь долоо хоногт	<ul style="list-style-type: none"> • 2018-2020 сүрьеэгийн төслөөр зөөврийн дижитал рентген аппарат нийлүүлсэн
2		Говь-Алтай	10-р сарын 2 дахь долоо хоногт	<ul style="list-style-type: none"> • Дээрх аймгуудад ҮЗЗ сүүлийн 3 жилд танилцах ажлаар очоогүй үлдсэн
3		Баян-Өлгий, Ховд	1-р сард	<ul style="list-style-type: none"> • 2018-2020 сүрьеэгийн төслөөр Ховд аймагт зөөврийн дижитал рентген аппаратын дагалдах хэрэгслийг нийлүүлсэн

Хөтөлбөр 6. ҮЗЗ-ийн ажлын албаны эд хөрөнгийн бүртгэлтэй танилцах, баталгаажуулах /Хавсралт 3/

Хяналтын хорооны хурлын шийдвэр: Гишүүд ҮЗЗ-ийн эд хөрөнгө болон түүний ашиглалт эдэлгээний байдалтай нэг бүрчлэн танилцаж, зохих үнэлгээг өгч гарын үсэг зурж баталгаажуулсан. Түүнчлэн олон жил хэрэглээд хуучирсан эд хөрөнгө болон хурдан элэгдэж, гэмтдэг ашиглалтын хугацаа богинотой жижиг эд зүйлс болох шилэн аяга, флаш гэх мэт зүйлсийг эд хөрөнгийн бүртгэлээс хасах хэрэгтэй гэсэн зөвлөмжийг өглөө. Үүнд:

- Цайны хэрэгсэл (цайны аяга таваг 6 хос)
- Тооны машин Casio GX-120N
- Тооны машин CTTTZEN
- USB диск, 2 giga.

Түүнчлэн 2008 оноос хойш ашиглаж байгаа дараах эд зүйлс гэмтэл доголдолтой болсон бөгөөд ашиглалтын шаардлага хангахгүй болсон тул хэрэглээнээс хасах хэрэгтэй гэж үзэж байлаа. Үүнд:

- Бичгийн шүүгээ төмөр
- Бичгийн шүүгээ модон
- Dell XPS Dual CPU I7, 400GB of RAM, Dell18 monitor,
- Bell 800C UPS blink тог баригч
- Богино долгионы зуух (X2-20MS)

Б.Оюундарь: Өнөөдрийн хуралд хүрэлцэн ирсэн нийт оролцогчиддоо баярлалаа.

Хурал 15 цаг 10 минутад өндөрлөв.

Тэмдэглэл хөтөлсөн:.....Л.Номин-Эрдэнэ, ҮЗЗ-ийн Ажлын албаны ажилтан

Хянасан.....Б.Оюундарь, ҮЗЗ-ийн зохицуулагч